

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дэрэм	Дугаар	L051
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баянтүмэн сум
Төрсөн газар	Дорнод аймгийн	Төрсөн он	Баянтүмэн сум
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гүний хийд, Сан бэйсийн хүрээ, Дэчин гэгээний хийд	Сүм хийдийн дугаар	ДОБГ 036, ДОЧБ 037, ДОЧХ 010
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7 сарын 24	Ярилцлага авсан хүн	Ж. Одгарьд

Дорнод аймгийн Булган сумын Гүний хийд, Сан бэйсийн хүрээ, Дэчин гэгээний хийд

Бид нэг судалгаан дээр тулгуурлаж яваа. Проф Б. Ринченгийн эмхтгэж гаргасан энэ судалгаанд Баянтүмэн сумд дөрвөн хийд тэмдэглээстэй байна. Сан бэйсийн хүрээ, Дашдаржаалин хийд, Юмын хурал, Хүйн хурал гэсэн хүрээ хийдүүд тэмдэглэгдсэн байна. Энэнээс өөр хурлын газар байв уу? энэ хэд маань хаана хаана байсан гэдэг талаар танаас тодруулах гэж явна даа?

Манай хийд бол Хойд хүрээ, Урд хүрээ гэж хоёр хийдтэй байсан юм. Намайг жаахан байхад лам нар нь баригдсан юм. Энэ урд Бат уул гэж байгаа. Тэрний тэнд Гүний хийд гэж байсан юм. Зүүн хойшоо Гэгээний хийд гэж байсан байх. Угтамын хийд гэж хойшоо хэцүү лам нартай хийд байсан юм гэнэ лээ.

-Энэ сумаас баруун тийшээ хийд байсан уу?

Байгаагүй.

-Баруун тийшээ хоёр хурлын газар байсан байна? Юмын хурал, Хүйн хурал гээд.

Мэдэхгүй. Би ердөө дуулаач үгүй. Би чинь эндэхийн хүн биш шүү дээ. Голын урд талын Аравжаргалантын хүн.

-Гүний хийд нь Бат уулынхаа яг ард нь уу?

Энгэр дээр нь юм л даа. Антений тогооны зүүхэн хажууд байсан.

-Гүний хийд нь хэдэн дугантай хэр олон ламтай хийд байсан бэ?

Тэрийг мэдэхгүй.

-Таны хамгийн тод санаж байгаа хурлын газар ямар газар байна?

Би ч жаахан байхдаа Ламын хийд гэдэгт цамд очиж үзэж байсан. Тэрнээс өөр ч юм үзээгүй хүн дээ би.

-Ламын хийд гэдэг маань?

Чойбалсанд байгаа.

-Тэр баруунтаа байгаа хоёр хурлын газрыг мэдэх ямар хүн байгаа бол?

Данжин яах бол? Нас бол мэдэхгүй. Дуулсан юм байж магадгүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Хар эрэгний тэнд нэг жаахан дов толгой байдаг. Одоо тэндээс чинь бурхан тахил гардаг. Тэр юу байсан юм. Одоо мэдэхгүй.

-Одоо тэр хавийг мэдэх ямар хүн байна?

Үзэмчингүүд л мэдэх байх.

-Тэгвэл Хар эрэгт үзэмчингийн хийд байсан юм болов уу?

Үзэмчингийн ч хийд биш л дээ. Та нарт ярих юм байна. Манайх Сан бэйсийн хошуу гэж байгаа. Хошууны том овоо Хан уул гэж байгаа. Дээр үед Хан уулаа хамгийн түрүүнд тахидаг байсан. 1945 оны үед Орос байхгүй болгочихсон. 1990 онд би нэг өвгөнтэй санаачлаад овоог нь босгочихсон. Тэгээд овоо босгоод тахиж байсан. 2006 онд цементтэй шавраар бүрчихсэн. Овоо гэж чулууг л хэлдэг биз дээ. Тэгээд тэр чулууг нь байхгүй болгочихсон. 2006 онд энэ овоог тахихад тэр өдөр шороо хийсээд өдөр харанхуй болсон. Бид лаа бариад сууж байсан. Гэрэл цахилгаан ч гэж байхгүй. Тэгээд тахиж чадаагүй. 2007 ондоо мөн тахиж чадаагүй. Саяхан нэг тахилаа гэж дуулдсан. Энийг нэг ярих хэлэх газар байвал хэлээд, аймгийн удирдлагад ч дуулгах хэрэгтэй байгаа юм. Овоог маань чулуугаар нь болгож өгөөч л гэж хэлж байна даа.